



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**БАЯНГОЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН
НАМД**

2024.08.06 № ГННТ-2024/13-УТА-НА-04
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын

018020614

нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Монгол Ардын намын Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга, хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баянгол сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр (.05 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Баянгол сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Баянгол сумын МАН-ын хорооны Тэргүүлэгчдийн
2024 оны 06-р сарын 18-ны өдрийн
хурлаар хэлэлцэж батлав.

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНООС СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2024.06.18

Баруунхараа

Үйл ажиллагааны хөтөлбөрийн уриа: **ХЯНАЛТТАЙ ТӨРИЙН ШУУРХАЙ
ҮЙЛЧИЛГЭЭ**

БАЯНГОЛ СУМЫН МАН-ЫН ХОРОО НЬ:

1. Хяналттай, ялгаварладаггүй, ил тод, нээлттэй үйл ажиллагаатай төр захиргааны байгууллагыг төлөвшүүлэх,
2. Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээний хүрээнд иргэд, сонгогчдоо эрт илрүүлэгт бүрэн хамруулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний чанар хүртээмжийг сайжруулах,
3. Суралцах, хөгжих хүрэлцээтэй орчинг бүрдүүлж, хүнээ хөгжүүлэн, хүний хөгжлийн индексийг улс, аймгийн дундаж түвшнээс дээшлүүлэх,
4. Бизнесийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд бүх талаар дэмжиж, эрх тэгш хөгжих нөхцөл боломжоор хангаж, иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлж, сум орныхоо хөгжлийн хүрсэн түвшинг ахиулахаар 3 бүлэг 10 зорилт 58 заалт бүхий үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан иргэд, сонгогчдодоо илгээж байна.

НЭГ. УЛС ТӨРИЙН ХҮРЭЭНИЙ АСУУДАЛ

1.1. ТӨР ЗАХИРГААНЫ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР


- 1.1.1 Хүлээж биш хүрч үйлчлэх зарчмаар сумын төр захиргааны байгууллагын үйл ажиллагааг иргэдээ ялгаварладаггүй, хуурдаггүй, ил тод, нээлттэй, хяналттай болгоно.
- 1.1.2 Сумын төр захиргааны байгууллагыг орчин үеийн дэвшилтэт техник, технологиор хангаж, ажиллах нөхцөлийг сайжруулна.
- 1.1.3 Үйл ажиллагааныхаа хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаар багын ИНХ-д улирал бүр танилцуулан иргэд, сонгогчдынхоо саналыг авч тэдэнтэйгээ хамтран хэрэгжүүлнэ.
- 1.1.4 Багийн Засаг дарга, хүн, малын эмч, байгаль хамгаалагч, цагдаагийн бүрэлдэхүүнтэй багийг хөдөөгийн малчид уруу сард нэгээс доошгүй удаа ажиллуулж, төр захиргааны үйлчилгээг шуурхай хүргэнэ.
- 1.1.5 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах системтэй ажлыг тогтмолжуулж, төвийн хэсгийг камержуулна.

1.1.6 Төр захиргааны байгууллагын боловсон хүчнийг чадваржуулж, намчирхахгүй, тогтвор суурьшилтай ажиллуулж, орон байраар хангахад дэмжлэг үзүүлнэ.

1.1.7 Ган, зуд, гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хамгийн бага эрсдэлтэй даван туулах нөхцөлийг хангаж, сургаж дадлагажуулна.

1.1.8 Төр захиргааны байгууллагын зарим боломжит ажил үйлчилгээг гэрээс цахимаар хийх боломжийг судалж, хэрэгжүүлж эхэлнэ.

1.1.9 “Хууль зүйн салбарын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд суманд ажиллаж байгаа албан хаагчдын ажиллах нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор сумын цагдаагийн хэсгийн барилгыг стандартын дагуу шинээр барина.



ХОЁР. НИЙГМИЙН ХҮРЭЭНИЙ АСУУДАЛ

2.1. БОЛОВСРОЛЫН АСУУДЛААР

2.1.1 Сургуулийн материаллаг баазыг бэхжүүлж, суралцах орчин, хүртээмжийг сайжруулах арга хэмжээний хүрээнд бага сургууль шинээр барьж, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, эд аж ахуйгаар хангана.

2.1.2 Суралцагчдын аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээний хүрээнд сургуулийн орчинг бүрэн камержуулна.

2.1.3 Дотуур байр, сургуулийн гал зуухны тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамжийг сайжруулна.

2.1.4 Дутагдалтай мэргэжлийн багш нарыг бүрэн хангаж, тэдний ажиллах орчинг бүрдүүлэх зорилгоор хэсэгчилсэн болон ганцаарчилсан гэрээ хэлцэл хийж тогтвор суурьшилтай ажиллуулна.

2.1.5 Сургуулийн өмнөх боловсролын барилгыг бариулж, шаардлагатай техник хэрэгслээр хангана.

2.1.6 Англи хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарч англи хэлний 2-оос доошгүй багшийг гадаад, дотоодын сургалтад хамруулна.

2.1.7 Сургуулийн нүхэн жорлонг өөрчилж, био болон орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгоно.

2.1.8 Элсэлтийн шалгалтад 750-иас дээш оноо авсан буюу 48 улирал дараалан онц сурсан суралцагч, холбогдох багш нарт урамшуулал олгох, алдаршуулах тогтолцоог бий болгоно.

2.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТАЛААР

2.2.1 Эрүүл мэндийн салбараас иргэдэд үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээнд шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, нийгмийн эрүүл мэндийг хөгжүүлэх цогц арга хэмжээ авна.


2.2.2 Эрүүл мэндийн төвийн амбулаториос бусад хэсгийн барилгыг шинээр барьж, шаардагдах техник хэрэгслээр хангана.

2.2.3 Эмийн сангуудын өрсөлдөх боломжийг жигд хангаж, эмийн чанар хүртээмжийг сайжруулна.

2.2.4 Эмнэлгийн ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл боломжийг бүрдүүлэн эмч, сувилагч, асрахуйн ажилтнуудыг гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр, МАН-ын мөрийн хөтөлбөрийн хүрээнд сургаж, дадлагажуулна.

2.2.5 Эрт илрүүлэгт иргэд сонгогчдоо бүрэн хамруулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тууштай, системтэй явуулж, хүн амын эрүүл мэндийн индексийг дээшлүүлнэ.

2.2.6 Халдварт өвчний голомтыг арилгах цогц арга хэмжээг авна.



2.3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГЭМ ХАЛАМЖИЙН ТАЛААР

2.3.1 Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд “Баян хөгжил сан”-гаас зайлшгүй шаардлагатай хэрэгжих боломжтой төсөл хөтөлбөрийг санхүүжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна.

2.3.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрөл бүрийн халамж, тусламжийг нэн тэргүүнд олгож хэвшинэ.

2.3.3 Хувиараа алт олборлогчдыг хууль, дүрэм журмын хүрээнд ялгаварладаггүй, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй, ил тод, шударгаар, дарамтгүйгээр дэмжин тусалж, эрсдэлгүй, аюулгүй ажиллагааг хангахад онцгойлон анхаарна.

2.4. УРЛАГ, СПОРТЫН ТАЛААР

2.4.1 Шинэ соёлын төв, спорт цогцолборыг шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслээр хангана.

2.4.2 Урлаг, спортоор улсын аварга, тив, дэлхийн медаль хүртсэн тамирчид, залуучуудад бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх, нутгийн бизнес эрхлэгч нартай хамтран ажиллах харилцаа холбоог тогтоож өгнө.

2.4.3 Үндэсний уламжлалт спорт, соёлын арга хэмжээг төрөл бүрээр дэмжиж, шаардлагатай хувцас хэрэгслээр хангана.

2.4.4 Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх үүднээс сагс, гар бөмбөг, шагайн харваа гэх мэт спортын уралдаант тэмцээнийг янз бүрийн хэлбэрээр явуулж, мэргэжлийн багшаар хангах бодлого хэрэгжүүлж, тогтвор суурьшилтай ажиллуулна.

2.5. АХМАД, ЗАЛУУЧУУД, ХҮҮХЭД БАГАЧУУДЫН ТАЛААР

2.5.1 Сумын ахмадын өргөөнд шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангаж, ахмадууд хөгжих, чөлөөт цагаа өнгөрүүлэх нээлттэй төв болгоно.

2.5.2 Залуучуудын байранд залуучууд хөгжих техник, тоног төхөөрөмжөөр хангаж, төрөл бүрийн сургалт, клуб, дугуйланг ажиллуулан залуучуудын хөгжлийн нээлттэй төв болгоно.

2.5.3 Баг бүрд хүүхдийн чөлөөт цагийг өнгөрөөх стандартын шаардлага хангасан тоглоомын талбайг байгуулж, мод зүлэг тарьж тохижуулна.

2.5.4 Ахмад настны хуулийн хүрээнд харьяалалгүй ахмадуудыг аж ахуйн нэгжид хуваарилах ажилд хяналт тавьж, дахин хуваарилна.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНИЙ АСУУДАЛ

3.1. АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААР

3.1.1 Уул уурхайн салбарын нийгмийн хариуцлагын хүрээнд хийж хэрэгжүүлэх арга хэмжээнд сумандаа оёдол, ахуй үйлчилгээний иж бүрэн төвийн барилгыг шинээр барих ажлыг тусгаж, үйлчилгээ явуулах нөхцөл боломжоор хангана.

3.1.2 Ноос, ноолуур, арьс ширэнд анхан шатны боловсруулалт хийх болон мал нядалгааны нэгдсэн цехийг байгуулна.

3.1.3 Суманд шинээр баригдсан ЖДҮ-ийн хөгжлийн төвийг түшиглэн хүнсний ногоо даршлах, талх, нарийн боовны цехийг тогтвортой ажиллуулна.

3.1.4 Сумын нутаг дэвсгэр дээр байгалийн баялаг, ашигт малтмалын зөвшөөрөгдсөн нөөцийг иргэн бүрд тэгш хүртээмжтэй, ялгаварлал, чирэгдэлгүй, авлига, ашиг сонирхлоос ангид хууль, журам, шийдвэрийн дагуу ашиглах эрх зүйн орчинг бүрдүүлж, "БАЯЛАГТАА ЭЗЭН-БАЯНГОЛЧУУД" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.2. СУМЫН ҮНДСЭН ҮЙЛДВЭРЛЭЛ БОЛСОН ГАЗАР ТАРИАЛАН, МАЛ АЖ АХУЙН ТАЛААР

3.2.1 Хагас эрчимжсэн болон фермерийн аж ахуйг дэмжин хамтран ажиллаж, малын тоо толгойг бэлчээрийн даацад тохирсон зохимжтой хэмжээнд барих зорилт тавина.

3.2.2 Мах, сүүний фермер, гахай, өндөгний аж ахуйг хувийн хэвшлийн оролцоотой байгуулахыг зүйл бүр дээр дэмжиж ажиллана.

3.2.3 Таримал ургамлыг хашаажуулах, малыг хариулгатай болгож, 5 сарын 15-аас 10 сарын 15 хүртэл тариан талбай руу малчдыг буулгахгүй байна.

3.2.4 Атрын 4 дүгээр аян, Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд төр засгаас хэрэгжүүлж буй арга хэмжээнд манлайлан оролцож салбарын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ.

3.2.5 Тэрбум мод, хүнсний хувьсгалын тавигдсан бодлого зорилтыг хэрэгжүүлж, нийтийн эзэмшлийн газар талбайд мод бут тариулах, хүнсний ногоо тариалалтыг 2 дахин буюу энэ хэмжээгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

3.2.6 Бэлчээрийн даац, малын тоо толгойг үндэслэн хадлан бэлчээрийн талбайн хуваарилалтад хяналт тавьж, дахин хуваарилах арга хэмжээг авч бизнесийн хадланг хязгаарлана.

3.2.7 Сумын газрын алба, аж ахуйн нэгжүүдийн санал тооцооллыг үндэслэн тариалангийн талбайг тэлэх зөв бүтцэд оруулах замаар эргэлтийн талбайг боломжтой хэмжээгээр нэмэгдүүлнэ.

3.2.8 Таримал ургамлын нэр төрлийг нэмэгдүүлэх, хөрс хамгаалах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

3.2.9 Мал эмнэлгийн болон үржлийн ажил үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

3.2.10 Хадлан бэлчээрийн ургамлын нэр, төрөл цөөрч чанар муудаж буй өнөө үед тэжээлийн ургамал тариаланчдыг дэмжиж, малчидтай гэрээ хэлцэл хийлгүүлэн МАА-н зудын эрсдэлийн зөв менежментийг хэрэгжүүлнэ.

3.2.11 Сумандаа залуу механикжуулагчдыг шинээр бэлтгэх курс нээх, өрхийн (хашааны) хүнсний ногоо үйлдвэрлэлийг бага, жижиг, дунд оврын төрөл бүрийн

техникээр хангах ажлыг холбогдох хувь хүн, албан байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

3.3. ДЭД БҮТЦИЙН ТАЛААР

3.3.1 Одоо байгаа цахилгаан, дулаан, цэвэр бохир усан хангамжийн ашиглалтыг сайжруулж, хүчин чадлыг нэмэгдүүлэх бодлого баримтална.

3.3.2 Баян, Гонир, Хараа багуудын өрхүүдэд дулааны улиралд цэвэр усыг хашаанд нь хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.3.3 Хараа багийн засмал замын зүүн, баруун талын худалдаа үйлчилгээний гудамж, Баян багийн нүүрэн эгнээ, Гонир багийн наадмын талбайн хойд хэсгийн айл өрхүүдийг цэвэр, бохир усан хангамж, халаалтын нэгдсэн системд холбоно.

3.3.4 “Орон сууц хөтөлбөр”-ийн хүрээнд сумын иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл боломжийг сайжруулан 50 айлын орон сууцыг шинээр барих ажлыг төр, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.

3.4. БАЙГАЛЬ ОРЧИНГ ХАМГААЛАХ ТАЛААР

3.4.1 Эзэнгүй, орхигдсон, эвдэрсэн газрын эзэн холбогдогчийг тогтоож, нөхөн сэргээлт хийлгэх, зайлшгүй тохиолдолд байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр нөхөн сэргээлт хийлгэнэ.

3.4.2 Хараа, Загдал, Баян голын хориотой бүсийн дэглэмийг тогтоож, зөвхөн жимсний болон мод, бут тариулах замаар хамгаалалтыг сайжруулна.

3.4.3 Ан амьтан, бэлчээрийн болон эмийн ургамлын тооллого, нөөцийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.4.4 Хөв цөөрөм байгуулах, нутаг амьгүй голын голидорлыг өөрчлөхгүйгээр газар тариалан, МАА-н усан хангамжийг нэмэгдүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

3.4.5 Хог, хаягдлыг ангилах байгальд ээлтэй арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.